

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255008>

ЯЗГУУРЫН БҮТЭЦ БОЛОН ХОЛБОГЧ ЭЛЕМЕНТ¹

Д.Төмөртоогоо

Үггүй хэл байдаггүйтэй адил язгуургүй үг байдаггүй. Залгамал бүтэцтэй монгол хэлний үгийн язгуур нь ямагт үгийн эхэнд байрлан тухайн үгийнхээ цөм утгыг хадгалж, цаашид шинэ үг үүсэн бүрэлдэх бааз суурь нь болдог үгийн бүтэцийн хамагийн бага нэгж юм. Язгуурын бүтэц нь үгийн бүтэцийн асуудал, үгийн бүтэц нь бүтээвэрийн тухай асуудал юм. Монгол хэл зүйн бүтээлүүдэд “*утгынхаа талаар цааш задарахгүй үгийн эхний хэсгийг язгуур, үгийн бүтэцэн дэх утга бүхий хамагийн бага нэгжийг бүтээвэр*” гэж тодорхойлсон байдаг. Тийм учраас язгуурын бүтэц, утга, байрыг бүтээвэрийн түвшинд авч үзвэл зохино.

Монгол хэлний үгийн бүтэцийн судлалд нийлмэл бүтэцтэй үгийн эхэн дэх язгуур, ялангуяа, анхдагч язгуурын тухай цухас дурдсан байдаг боловч тэдгээрийн бүтэц хийгээд түүний араас залган орж, үүсмэл язгуур бүтээсэн дагаваруудын үүрэгийн тухай асуудал төдий л тодорхой судлагдаагүй байна.

Монгол хэлний язгуур бүтээвэрийн бүтэцийн тухай асуудалыг W. Kotwicz анх түрүүн анхааран судалж, {(C)-CVC, (C)V-CCV, VCV CVCV} зэрэг бүтэцийг тогтоосон билээ.² Түүний дараахан N. Poppe монгол хэл аялгуу болон түрэг, түнгүс хэлний үгийн бүтэцийг харьцуулан судалсаны үндэсэн дээр V, VC, CV, CVC гэсэн дөрвөн үндэсэн бүтэцийг тогтоосон³ бол хожим Ш. Лувсанвандан орчин цагийн монгол хэлний үгийн бүтэцэн дээр тулгуурлан V, VC, CV гэсэн бүтэц бүхий анхдагч язгууруудыг сэргээн тогтоожээ.⁴ Дээр дурдсан судалгаануудаас гадана монгол хэлний язгуур бүтээвэрийн талаар П.Бямбасан, П.А.Дарваев, Го.Мижиддорж, Ц.Норжин, О.Самбуудорж, Түмэнжаргал зэрэг судлаачидын бүтээл гарсан буй.⁵

¹ Энэхүү өгүүллийн бичвэрийг “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” бичгийн дүрмийг дагалгүй Академич Д.Төмөртоогогийн өөрийнх нь баримталдаг зарчмыг тэр хэвээр хадгалж хэвлэв.

² W. Kotwicz, *Studia nad językami altajskimi*, Krakow, 1953, 33-46

³ N. Poppe, Remarks on Some Roots and Stems in Mongolian, “*Silver Jubilee Volume of the Zinbun Kagaku Kenkyusyo Kyoto University*”, Kyoto, 1954, 294-300

⁴ Sh. Luvsanvandan, Remarks on Some Roots and Stems in Modern Mongolian, “*Studies in General and Oriental Studies*” (Presented to Shiro Hattori on the Occasion of His Sixtieth Birthday), Tokyo, 1970, 423-425

⁵ П.Бямбасан, Монгол хэлний үгийн язгуур, үндсийн тухай асуудал, ХЗС 9:1, 1972, 5-13; Орчин цагийн монгол хэлний үйл үгийн идэвхгүйг язгуурын тухай зарим ажиглалт, ХЗС 16:4, 1987, 18-44 // П.А.Дарваев, О формировании различных корневых гнезд от общих праформ в монгольских и тюркских языках, “*Вопросы калмыцкой филологии*”, Элиста, 1984, 44-49 // Го.Мижиддорж, Манж, монгол хэлний ижил язгуурт үндсийн бүтээврийн бүтцийн өвөрмөц тохироо, ХЗС 12:11, 1977, 149-159 // Ц.Норжин, Jemdeg ijaγur-un tuqai, MKUJ 2, 1980, 24-33 // О.Самбуудорж, Монгол хэлний үгийн эртний язгуур болон утгыг дагавар бүтээврээр эгнээ үүсгэн судлах асуудалд, ХЗС 9(41):1, 2016, 5-17 // Түмэнжаргал, *Mongyol töröl-ün kelen-ü üge-yin ijaγur-un бүтүцэ-yin tuqai*, MKB

Хэдий тийм боловч анхдагч язгуурын бүтэцийн тухай асуудал одоо хүртэл маргаантай хэвээрээ байна. Тухайлбал, Чой Лувсанжав, Б.Базылхан нар⁶ алтайн хэл болон монгол хэлний үгийн бүтэцийн харьцуулал дээр тулгуурлан монгол хэлний анхдагч язгуур нь V, CV гэсэн хоёр төрөлийн бүтэцтэй байсан гэж үзсэн бол М.Базаррагчаа⁷ зөвхөн CV гэсэн бүтэцтэй байсан гэж үзээд, түүнийгээ “*үе утгалбар*” хэмээн нэрийдсэн байна.

Бид энэхүү үгүүлэлдээ анхдагч язгуурын бүтэц хийгээд үүсмэл язгуур бүтээх дагаварууд, тэдгээрийн үүрэгийн тухай асуудалыг дахин нэг хөндөж тавих зорилт тавьлаа.

Монгол хэлний судлалд язгуур бүтээвэрийг тогтоохдоо их төлөв үгийн сангийн утгад тулгуурласаар иржээ. Гэтэл үгийн язгуурын тухай асуудал нь зөвхөн үгийн утга төдийгүй, үгийн бүтэцийн тухай асуудал юм. Тийм учираас язгуур бүтээвэрийг тогтоохдоо зөвхөн үгийн сангийн утгыг харгалзах нь цөм утгаа хадгалж байгаа анхдагч язгуурыг илэрүүлэхэд учир дутагдалтай. Тийм учираас нийлмэл бүтэцтэй үгийн доторхи үг бүтээх дагаваруудыг араас нь дараалан хассаар үгийн эхний язгуурт тулгах нь язгуурыг тогтоох хамагийн зохистой арга юм. Энэ талаар Б. Ринчен, “*утга бүхий хэсгээр нь салгасаар байтал тухайн үгийг уг утга санааг агуулан хадгалсан бөгөөд цаашаа салахгүй буюу хуваан хэсэглэтэл салгадгийн чанад хязгаарт тулсан хэсэг үлдэнэ. Түүнийг язгуур гэнэ. Утга бүхий хэсгийг нэгд нэгэнгүй салгасаар язгуурын утга санаа агуулсан хэсэгт хүрвээс язгуур үг гэдэг маань гарч ирэх юм*”⁸ хэмээн тодорхойлсон байна.

Миний бие дээрхи зарчмыг баримтлан эртний бичигийн дурасхал, хожуу үеийн монгол түүхэн сурвалж бичигүүд болон толь бичигийн материал дээр тулгуурлан нийлмэл бүтэцтэй үгсийн хөмөрөг бүрдүүлж, язгуур бүтээвэр хийгээд залгавар бүтээвэрүүдийн бүтэц, байр, үүрэгийг үгсийн аймаг тус бүрээр ялган тодорхойлсон ганц сэдэвт бүтээлийг⁹ арав гаруй жилийн өмөнө нийтлүүлсэнээс гадна нэг язгуураас салбарлан гарсан ойролцоо утга бүхий үгсийн шаталсан эгнээ үүсгэсэн толь бичигийг¹⁰ эмхэдхэн нийтлүүлсэн билээ.

Хэл шинжилэлд үгийн язгуурийн дотоод бүтэц болон хэл зүйн харьцаанд орох чадамжийг нь харгалзан хоёр өөр талаас авч үздэг. Үүнд:

1. Үгийн язгуурыг дотоод бүтэцийнх нь талаас ‘анхдагч язгуур’, ‘үүсмэл язгуур’ гэсэн хоёр зүйлээр ангилдаг.

а. Цаашид утгат хэсэг болж задрахгүй хэсэгийг “анхдагч язгуур” гэж тодорхойлдог. Жишээлбэл: 2, 3, 4 гэсэн тооны үгийн цөм утгыг хадгалсан **ji-* **yu-*, **dö* болон ‘цагаан’, ‘гэгээн’ гэсэн тэмдэг үгийн цөм утгыг хадгалсан **ca-*, **ge-*

1, 2003, 31-36; *Mongyol kelen-ü -sa/-se ~ -so/ -su, -sü* iḡayurtu üges-ün sinjilel, ÖMYS 6, 2013, 1-10; *Mongyol kelen-ü ‘qa’ iḡayurtu törül üges-ün tuḡai*, ÖMYS 2, 2017, 1-14

⁶ Choi. Luvsanjav, On the Types of Mongolian Word Roots, *Fifth International Congress Mongolists*, Vol. II, 1992, 380-381; A Contrastive Analysis of the Morphological Structure of Words in Mongolian and English, Ulaanbaatar, 60-70 // Б. Базылхан, Монгол хэлний бүтээврийн тухай асуудалд, ХЗС 14:8, 1980, 32; Түрэг хэлнүүдийн харьцуулсан судалгааны дүнгээс, *Bulletin IAMS* № 17, 18, 1996, 98-99

⁷ М. Базаррагчаа, Эртний монгол хэлний анхдагч бүтээврийн утга, *Bulletin IAMS* 1(29), 2002, 61-67; Эртний монгол хэлний үгийн язгуур нь CV илэрхийлбэрээр илэрч “бүтэх, эвдрэх” утгатай болох нь, “*Монгол хэлний бүтээвэр судлал*” {= Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган. II боть}, Уб., 2017, 175-249

⁸ Б.Ринчен, Монгол бичгийн хэлний зүй. Хэлбэр судлал. Гутгаар дэвтэр. Уб., 1966, 14

⁹ Д.Төмөртоогоо, Монгол хэлний бичигийн дурасхалуудын үгийн бүтэцийн харьцуулсан судалгаа. (уйгуржин монгол, дөрвөлжин, араб, хятад үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний бичигийн дурасхалууд) Уб., 2011, 221 тал.

¹⁰ Д.Төмөртоогоо, Монгол хэлний үгийн бүтцийн толь, Уб., 2015, 356 тал.

зэрэг нь *анхдагч язгуур* болох бөгөөд тэдгээр нь үгийн сангийн утга илэрхийлэхгүй, хэл зүйн харьцаанд бие даан орох чадамжгүй.

б. Тухайн үгийнхээ цөм утгыг хадгалсан *анхдагч язгуур*-ын дээр дагавар залгаж бүтсэн нийлцийг “*үүсмэл язгуур*” гэдэг. Жишээлбэл: тооны үгийн **ji-* **yu-*, **dö* гэсэн анхдагч язгуур дээр -*r* залгаж *jir-*, *yur-*, *dör-* гэсэн *үүсмэл язгуур* үүссэн боловч тэдгээр нь үгийн сангийн утга илэрхийлэхгүй, хэл зүйн харьцаанд бие даан орох чадамжгүй хэвээрээ байгаа билээ. Дээр дурдсан тооны үгсийн *үүсмэл язгуурыг* бүтээсэн тэрхүү -*r* гэсэн залгавар нь үгийн сангийн утгатай шинэ үг бүтээж чадахгүй ч гэсэн өмөнө талынхаа анхдагч язгуурыг үг бүтээх дагавартай холбох завсарын үүрэгтэй байгааг харгалзан бид энд түүнийг ‘*холбогч элемент*’ хэмээн нэрийдэв. Монгол хэлний үгийн бүтэцийн тогтолцоонд тийнхүү анхдагч язгуур, үг бүтээх дагавар хоёрыг холбох үүрэгтэй элемент байгааг үгүйсгэх аргагүй бөгөөд бид энд түүнийг *дагавар*, эсвэл *бүтээвэр* хэмээн шууд нэрлэх боломжгүй байсан тул үүрэгийг нь харгалзан ‘*холбогч элемент*’ хэмээн нэрлэсэн болно. Дээрхи жишээнд дурдсан үг бүтээх үүрэггүй, завсарын шинжтэй -*r* залгавар болон түүнтэй адил үүрэгтэй бусад ‘*холбогч элемент*’-үүдийн бүтэц, байр, үүрэгийг олон талаас нь харгалзан үзэж, цаашид хэрхэн авч үзэх тухай асуудалыг хойно дахин дурдах болно.

Тооны үгийн **ji-* **yu-*, **dö* гэсэн анхдагч язгуур дээр зөвхөн ‘*холбогч элемент*’ залгадаг төдийгүй, бас дагавар залгаж, *jici*, *yuçi*, *döçi* гэсэн тооны үг үүссэн байгааг харж болно. Гэвч энэ нь **ji-* **yu-*, **dö* гэсэн анхдагч язгуур дээр *çi* дагаварыг шууд залгасан хэрэг биш, харин анхдагч язгуур болон үг бүтээх дагавар хоёр нь материаллаг дагавараар бус, түүнтэй адил үүрэгтэй тэг дагавараар холбогдож, хэл зүйн харьцаанд чөлөөтэй орох чадамжийг бүрдүүлж буй хэрэг юм. Үүнтэй холбогдуулан П. Бямбасан: “*нөхцөлийн өмнө үндэс үүсгэх тэг морфемтой тохиолдох язгуурыг идэвхитэй язгуур, нөхцөлийн өмнө дагавартай тохиолдох язгуурыг идэвхигүй язгуур гэнэ*” хэмээн тодорхойлсоныг дурдвал зохино. Дээрхи тодорхойлолтод: “*нөхцөлийн өмнө үндэс үүсгэх тэг морфем*”¹¹ хэмээсэн нь угтаа бидний дээр дурдсан *jici*, *yuçi*, *döçi* гэсэн тооны үгсийг тийн ялгалын нөхцөлийн өмөнө орох чадамжтай болгосон тэг бүтээвэрийг хэлж байгаа хэрэг. Таширамд дурдахад: Тэг бүтээвэрийн байр, үүрэгийн талаар илүү бодьтой ойлгохын тул материаллаг болон хийсвэр нэгжүүдийн бүтэц болон байрлалыг нь сайтар харьцуулан үзэж, хийсвэрлэн бодох шаардлагатай. Хийсвэрлэн бодох гэдэг хэдийгээр таамаг мөн боловч тэр нь онолын бодит үндэслэлтэй, баримтаар нотлогдсон байх ёстой.

Бид энд *үүсмэл язгуурын* дотоод бүтэц, үүрэгийн тухай асуудалыг илүү тодорхой, ойлгомжтой болгохын тул өөр нэг жишээтэй жишиж үзэх нь зүйтэй гэж үзэж байна. Зөвхөн үгийн эхэнд тохиолддог **ca-*, **ge-* гэсэн өнгө заасан язгуурын дээр -*yā/-gē* дагавар залгаж, *čayā*, *gegē* гэсэн *үүсмэл язгуур* бүтээж болох бөгөөд тэр нь тэг бүтээвэрээр дамжин хэл зүйн харьцаанд орох чадамжтай *čayā*, *gegē* гэсэн үндэс болж чадна. Түүнчилэн *čayā*, *gegē* гэсэн *үүсмэл язгуурын* дээр -*n*, -*ra* /-*re* дагавар залгаж *čayān*, *čayāra-* // *gegēn*, *gegēre-* гэх мэт үгийн сангийн утгатай өөр шинэ үг бүтэж, цаашид хэл зүйн харьцаанд орох бодит нөхцөл бүрдсэн байна.

2. Үгийн язгуурыг хэл зүйн харьцаанд шууд орох чадамжийнх нь талаас ‘*чөлөөт язгуур*’, ‘*чөлөөт бус язгуур*’ гэсэн хоёр зүйлээр ангилдаг.

а. Хэрэв тухайн үгийн язгуур нь үгийн сангийн утгаа хадгалж, үг холбох нөхцөлөөр дараах үгтэйгээ шууд холбогдож, хэл зүйн харьцаанд орж байвал түүнийг ‘*чөлөөт язгуур*’ (free root) гэдэг. Жишээлбэл: *mal*, *yar*, *jam* гэх мэт үгс нь

¹¹ П.Бямбасан, Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг, Уб., 1975, 10

бүтэцээрээ цаашид задарахгүй учир язгуурын шинжийг хадгалж байгаагаас гадана тэг бүтэцээр дамжин хэл зүйн харьцаанд чөлөөтэй орох чадамжтай байгаагаараа *чөлөөт язгуур* болно. Монгол хэл зүйн бүтээлүүдэд *чөлөөт язгуур*-ыг их төлөв *‘идэвхитэй язгуур’* хэмээн нэрлэсээр иржээ.

б. Хэрэв тухайн үгийн язгуур нь уул үгийнхээ цөм утгыг хадгалж байгаа боловч үгийн сангийн бие даасан утга илэрхийлж чадахгүй, бас хэл зүйн харьцаанд шууд орох чадамжгүй байвал тэр нь *“чөлөөт бус язгуур”* (bound root) болно. Монгол хэл зүйн судалгааны гол бүтээлүүдэд *чөлөөт бус язгуур*-ыг их төлөв *‘идэвхигүй язгуур’*, хэмээн нэрлэсээр иржээ.¹² Мөн зарим бүтээлд *‘мөхсөн язгуур’* гэж нэрлэсэн нь ч бас бий. Монгол хэлний *дүрслэх үг*-ийн язгуур нь бусад аймагийн үгсээс илүүтэйгээр цөм утгаа хадгалсан *чөлөөт бус язгуур* болдог байна.

Чөлөөт бус язгуур нь бүтэцийнхээ талаар ч, утгынхаа талаар ч *анхдагч язгуур*-тай тохирно. Түүнчилэн анхдагч язгуурын дээр үг бүтээх үүрэггүй *‘холбогч элемент’* залгаж үүссэн *үүсмэл язгуур* ч бас *чөлөөт бус язгуур* болно. Тухайлбал: *ᠵᠢᠷ*-, *-ᠵᠢᠷ*-, *-ᠳᠣᠷ*- гэсэн тооны үгийн *үүсмэл язгуурууд* нь хэл зүйн харьцаанд шууд орж чадахгүй учир бас л *“чөлөөт бус язгуур”* болно. Гэвч тэр нь дээр дурдсанчилан өмөнөх язгуур болон дараах дагавар хоёрыг холбох үүрэгтэйгээрээ анхдагч язгуураасаа ялгаатай.

Монгол хэлний язгуур бүтээвэр, ялангуяа анхдагч язгуурын бүтэцийн талаар Чой Лувсанжав, Б. Базылхан, М. Базаррагчаа өөр өөр үзэл баримтлалтай байгаа талаар өмөнө дурдаж өнгөрсөн. Гэтэл эртний бичигийн дурасхалууд, хожуу үеийн түүхэн сурвалж бичигүүд хийгээд монгол хэлний толь бичигүүдээс үзвэл монгол хэлэнд V, VC, VCV, VCCV, CV, CVCV, CVC, CVCCV гэсэн бүтэцтэй язгуурууд байгааг түвэггүй мэдэж болно. Бид энд тэдгээрээс жишээ болгож хамагийн нийтлэг хэдэн зүйлийн язгуурын бүтэцийг тодорхой жишээгээр үзүүлэе. Үүнд:

а. ЭГ (VC) бүтэцтэй язгуур: *ab-* (ab-čira-, ab-/u/ya, ab-qa-yül-, ab-qu, ab-ta-), *eb-* (eb-de-, eb-le-, eb-se-, *is-* (is-ke-, is-l(ü)g, is-kü-leng, is-(ü)l, is-(ü)meg, is-(ü)mel; *ol-* (ol-buri, ol-da-, ol-γu-, ol-ja, ol-/u/lča-); *uy* (uy-ja-, uy-la-, uy-sa-γa, uy-sa-ra-, uy-sil)

б. ЭГГЭ (VCCV) бүтэцтэй язгуур: *alba* (alba-da-, alba-n, alba-tu-), *orči-* (orči-l, orči-lang, orči-lta, orči-n); *örge-* (örge-d-ke-, örge-de-, örge-ji-, örge-lte, örge-mji); *uryu-* (uryu-ča, uryu-čay, uryu-yül-, uryu-lta, uryu-mal); *ürči-* (ürči-be-lje-, ürči-g, ürči-gene-, ürči-ger, ürči-lje-, ürči-yi-)

в. ГЭ (CV) бүтэцтэй язгуур: **ča-* (ča-γā-btur, ča-γā-d-qa-, ča-γā-da-, ča-γā-γčin, ča-γā-lγa, ča-γā-n, ča-γā-lsun) // ča-yi-, ča-yi-bur, ča-yi-dam, ča-yi-lγa-n, ča-yi-r, ča-yi-ra-); **ge-* (ge-gē, ge-gē-bči, ge-gē-n, ge-gē-re-, ge-re, ge-re-l, ge-yi-, ge-yi-gül); **de-* (de-b-ji-, de-b-ke-r, de-b-ši-, de-g-de-, de-g-ji-, de-gē-dü, de-gē-gür, de-gē-gši, de-gē-ji, de-gē-re); *ne-* / *ni-* (ne-yi-če, ne-yi-d-ke-, ne-yi-gem, ne-yi-l-büri, ne-yi-le-, ne-yi-s-le-l, ne-yi-te // ni-ge, ni-ge-d-, ni-ge-n, ni-ji-ged); **qo-* (qo-čar-, qo-ji-da-, qo-ji-γda-, qo-ji-m, qo-yi-či, qo-yi-du, qo-yi-mar, qo-yi-na, qo-yi-ši)

д. ГЭГЭ (CVCV) бүтэцтэй язгуур: *baya-* (baya-čüd, baya-d, baya-ji-, baya-liγ, baya-n, baya-r, baya-r-la-, baya-r-tu, baya-s-, baya-s-qa-, baya-s-qu-lang); *bökü-* (bökü-čü-gene- bökü-čü-ger, bökü-gene-, bökü-ger, bökü-lje-, bökü-s-ki-, bökü-tü-gene-, bökü-tü-ger, bökü-tür, bökü-yi); *daba-* (daba-γā, daba-γda-, daba-γū, daba-lγa, dabara-); *ᠵasa-* (ᠵasa-buri, ᠵasa-γ, ᠵasa-γül, ᠵasa-l, ᠵasa-mal, ᠵasa-ra-); *küčü-* (küčü-de-, küčü-le-, küčü-n, küčü-rde-, küčü-rke-, küčü-tü); *mede-* (mede-če-, mede-gči, mede-gde-, mede-gē, mede-gül-, mede-l, mede-lge, mede-re-); *qaya-* (qaya-ča-, qaya-čal, qaya-l-,

¹² Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. (Үг, нөхцөл хоёр), Уб., 1968 102-121; П. Бямбасан, Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг, Уб., 1975, 7; Ц. Өнөрбаян, Орчин цагийн монгол хэлний үг зүй, Уб., 1998, 77

qaya-ra-, qaya-rqai, qaya-s); **tata-** (tata-buri, tata-γa-lja-, tata-γana-, tata-γda-, tata-γū, tata-lida-, tata-mal, tata-si, tata-yi); **yada-** (yada-γū, yada-γū-ra-, yada-γū-s, yada-may, yada-ngi, yada-ra-, yada-ra-l)

e. ГЭГ (CVC) бүтэцтэй язгуур: **bay-** (bay-ča, bay-la-, bay-sa-r, bay-sa-yi-, bay-si-ra-, bay-ta-, bay-ta-γā-); **dal-** (dal-ba-γā, dal-ba-γar, dal-bi-γar, dal-da-γar, dal-ji-γar); **γar-** (γar-bali, γar-ča, γar-γa-, γar-u/γa, γar-u/l); **jab-** (jab-či-la-, jab-du-, jab-qa-, jab-sar, jab-ši-); **sal-** (sal-ba-γar, sal-ba-r, sal-ba-yi-, sal-γa-, sal-/a/γā, sal-γana-)

f. Э (V) Эртний монгол хэлэнд дан эгшиг (V)-ээс бүтсэн анхдагч язгуур байсаныг үйл үгийн ихэнхи нөхцөлөөр хэлбэржсэн ***a-** язгуурт туслах үйл үгийн дараах жишээнээс харж болно. Үүнд: **a-** (*a-γtun*) / *a-dqun*, *a-γa*, *a-su-γai*, *a-tu-γai*, *a-mi* / *a-mui*, *a-yu*; үйлийн цагаар төгсгөх *a-ba*, *a-bai*, *a-lu'ā*, *a-ju'ū* / *a-juγū*, *a-ju'ūi* / *a-juγūi*, үйлийн тододхон холбох *a-qu* / *a-qui*, *a-γsan*, *a-γči*, *a-'ai* / *a-γai* үйлийн нөхцөлдүүлэн холбох *a-ju*, *a-n*, *a-tala*, *a-run*, *a-basu* гэсэн нөхцөлүүдийг дурдаж болно. Монгол хэлний бичигийн дураасхалуудад өөр ийм жишээ тохиолдохгүй байна.

Хэрэв Чой.Лувсанжав, Б.Базылхан нарын үзсэнчилэн эгшигээр эхэлсэн бүх үгийн эхний Э (V) нь язгуур байсан гэж үзвэл, бидний дээр дурдсан ЭГ (VC) бүтэцтэй **ab-**, **eb-**, **is-** **ol-**, **uy-** гэсэн үгс нь **a-**, **e-**, **i-**, **o-**, **u-** язгуур, **-b**, **-s**, **-l**, **-γ** гэсэн дагавараас бүтсэн болж таарна. Мөн Чой. Лувсанжав, Б. Базылхан, М. Базаррагчаа нарын үзсэнчилэн монгол хэлэнд ГЭ (CV) гэсэн бүтэцтэй язгуур нийтлэг шинжтэй байдаг нь үнэн боловч гийгүүлэгчээр эхэлсэн бүх үг нь ГЭ (CV) гэсэн язгууртай байсан гэж үзэх боломжгүй. Хэрэв гийгүүлэгчээр эхэлсэн үг бүхэн бол ГЭ гэсэн язгууртай байсан гэж үзвэл бидний дээр дурдсан ГЭГЭ (CVCV) бүтэцтэй **baya-**, **daba-**, **jas-a**, **küčü-**, **mede-** гэх мэт үгс нь **ba-**, **da-**, **ja-**, **kü-**, **me-** гэсэн язгууртай, **-ya**, **-ba**, **-sa**, **-čü**, **-de** гэсэн дагавартай байсан болж байна. Мөн түүнчилэн ГЭГ (CVC) гэсэн бүтэцтэй **bay-**, **dal-**, **γar-**, **jab-**, **sal-** зэрэг үгс нь **ba-**, **da-**, **γa-**, **ja-** **sa-** гэсэн язгуур, **-γ**, **-l**, **-r**, **-b** гэсэн дагавараас бүтсэн мэт ойлгогдож байна. Дээр дурдсан үгсийн эхний Э (V) болон ГЭ (CV) нь цөм утгыг хадгалсан эсэх, мөн түүний дараа орсон CV, C гэсэн бүтэц нь үг бүтээх дагавар болж чадах уу гэдэгийг мэргэжилийн судлаачид шүүн тунгаах буй заа.

Язгуур бүтээвэрийн эртний бүтэцийг тогтоохдоо утгын хийсвэрлэл байж болох ч гэсэн хийсвэр санаандаа хэт хөтлөгдөн хэлний бодит баримтаас гажиж, адил цөм утга агуулаагүй, үгийн сангийн утгаараа ч уялдаа холбоогүй өөр өөр үгсийн төстэй дуудлага бүхий эхний үеийг хүчээр холбон, язгуурын түвшинд авч үзсэн нь хэрэг дээрээ авиа зүйн түвшиний нэгэжийг үг зүйн түвшиний нэгэж болгон авч үзсэн хэрэг юм. Хэлний бүтэц, тогтолцоог тогтоохдоо баталгаатай баримт, үнэмшилтэй гаргалгаан дээр тулгуурлах ёстой. Хэрэв монгол хэлний үгийн бүтэцийг түүхэн үүднээс авч үзэх бол монгол хэлний мянган жилийн түүхийг агуулсан эртний бичигийн дураасхалуудаас ганц ч жишээ таталгүй, адил төстэй үеүдийг дан ганц хийсвэрлэлээр үг зүйн түвшинд аваачиж, үгийн язгуурт тооцох нь өрөөсхөл хандлага юм. Хийсвэрлэн бодох аргаар онолыг үндэсийг төсөөж болох боловч хийсвэрлэсэн төсөөлөлөө хөдөлшгүй баримтаар нотлох нь шинжилэх ухааны ёс. Хэрэв төсөөлөлдөө хөтлөгдөн баримтыг гуйвуулбал ...

Язгуурын бүтэцийг бодьтой тогтоохын тул дагаварын бүтэц, байр, үүрэгийн талаар илүү тодорхой мэдвэл зохистой. Ялангуяа чөлөөт бус язгуурын дараа орсон залгавар, чөлөөт язгуурын дараа орсон залгавар хоёрын байр ба үүрэгийн адил ба ялгаатай талыг илүү тодоруулах нь чухал. Тухайлбал: **jī-**, ***γu-**, ***dö-** гэсэн анхдагч язгуураас **jir-**, **γur-**, **dör-** гэсэн үүсмэл язгуурыг бүтээсэн дээр **-r** залгавар нь үг бүтээх чадамжгүй шинжээрээ өмөнөх язгууртайгаа адил мэт боловч үг бүтээх дагавартай холбогдож, үгийн сангийн үг бүтээх чадамжтайгараа ялгаатай. Гэтэл

уул **yu-*, **dö-* язгуур дээр *-na/-ne* дагавар залгахад *yuna, döne* гэсэн үгийн сангийн утгатай шинэ үг үүсэж, уламаар тэр нь дараах үгтэйгээ холбох нөхцөлөөр холбогдох чадамжтай болж байна. Энэ нь чөлөөт бус язгуур дээр залгаж буй дагаварууд өөр өөр чадамжтай байгааг харуулж байна. Тийм учираас чөлөөт язгуураас үүсмэл язгуур бүтээж буй дагаваруудыг байрлалаар нь, чадамжаар нь ангилж, тэдгээрийг оновчтой нэр томъёогоор ялгах нэрлэх шаардлагатай болж байна.

Abstract

The structure, distribution, and meaning of word roots in Mongolian have been the subject of extensive study for many years. Most scholars agree that the structure of Mongolian word roots can be categorized as VC, VCV, VCV, CV, CVCV, and CVC. However, some researchers argue that root morphemes in Mongolian are limited to the structures V and CV. While the CV structure is quite common in Mongolian, but it is difficult to accept the notion that all Mongolian word roots conform exclusively to this pattern. Furthermore, there are not available instances of roots consisting of a single vowel in Mongolian, with the notable exception of the Ancient Mongolian auxiliary verb *a-. Therefore, it is essential to clarify the structure of word roots and derivative roots in the Mongolian language.